



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/335

Хэрлэн сум

Хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалтад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гуравдугаар хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.1.6.4 дэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Хүний эрхийн талаарх суурь ойлголтыг иргэд болон төрийн албан хаагч нарт таниулан ойлгуулах, сурталчлах ажлын хүрээнд сумдын Хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулахад 2,117,360 (хоёр сая нэг зуун арван долоон мянга гурван зуун жаран) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ





$\frac{100}{\text{پیش}}$
 $\frac{60}{\text{پیش}}$
 $\frac{200}{\text{پیش}}$

نصیر و احیاء ندر اہمیتسن وسہن
وسہن و اہمیتسن کو نصیر و احیاء ندر اہمیتسن وسہن